МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
Төрийн Өмчит Хувьцаат Компани

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 16 өдөр Дугаар А/164 Улаанбаатар хот

"Ачаа тээвэрлэлтийн тариф хэрэглэх дүрэм"-д
нэмэлт оруулах тухай

Төмөр замын тээврийн тухай хуулийн 7дугаар зүйлийн 7.1, 18 дугаар зүйлийн 18.3.3, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.12.11, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 тоот албан даалгавар 9.13, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 645 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшин 2022 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 02 дугаартай тээвэр эхлүүлэх тухай тогтоол, Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар баталсан суурь бүтэц ашиглалтын тариф тогтоох аргачлалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төмөртэй-Хандгайт чиглэлийн төмөр зам, Цогтцэций-Зүүнбаян чиглэлийн төмөр замд хэрэглэгдэх "ачаа тээвэрлэлтийн тариф хэрэглэх дүрэм"-ийг хавсралтаар нэмэлтээр баталж, 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/19 дугаар тушаал, 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/28 дугаар тушаалуудыг үргэлжлүүлэн мөрдсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тээвэр, логистикийн газрын дарга /Б.Ууганхүү/, Санхүү эдийн засгийн газрын дарга /Н.Даваажаргал/, Хяналт шалгалтын газрын дарга /М.Амарсайхан/ нарт даалгасугай.

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ ТӨХК
1117144653
УХМ0079 5214203

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ П.ГАНХҮҮ

2022001127

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн
Б/184 дугаар тушаалын хавсралт.

## СУУРЬ БҮТЭЦ АШИГЛАЛТЫН ХӨЛС

“МТЗ” ТӨХК-ийн эзэмшлийн бус зүтгүүр болон хөдлөх бүрэлдэхүүнээр тээвэрлэж буй тохиолдолд суурь бүтцийн ашиглалтын хөлсийг тонн километр тутмаас 0,022 ам.доллараар /сар бүрийн эхний өдрийн монгол банкний ханшаар шинэчлэн/ тооцно.